



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/98/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 276

танай _____-ны № _____-г

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.БОЛОРТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төв нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 91,0 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020056



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26803700.90	35861519.21
35	БАРАА МАТЕРИАЛ	26803700.90	35861519.21
351	Түүхий эд материал	710338.00	10492699.31
35110	Тусгай зориулалттай материал	710338.00	710338.00
35130	Эм боох материал	0.00	9782361.31
354	Хангамжийн материал	26093362.90	25368819.90
35420	Аж ахуйн материал	24777051.90	25368819.90
35460	Хүнсний материал	803161.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	513150.00	0.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	441168822.29	602078138.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	441168822.29	602078138.70
392	Биет хөрөнгө	422568822.29	583478138.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	345253079.85	474557675.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8512228.32	-17281013.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31000000.00	68900000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17764705.96	-26449428.23
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52747672.00	69434372.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19111168.18	-25313709.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29991507.46	35996507.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12369838.68	-15278713.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	24320560.00	24320560.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2986055.88	-5408111.88
393	Биет бус хөрөнгө	18600000.00	18600000.00
39301	Програм хангамж	200000.00	200000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200000.00	-200000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18600000.00	18600000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	467972523.19	637939657.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	467972523.19	637939657.91
51	Засгийн газрын хувь оролцоо	467972523.19	637939657.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	271,665,616.37	271,665,616.37
512	Хуримтлагдсан үр дүн	5670579.64	175637714.36
51210	Өмнөх үеийн үр дүн	5670579.64	5670579.64
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	169967134.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190636327.18	190636327.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	467972523.19	637939657.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	388081919.00	599801844.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32640429.00	200251639.15
120	Нийтлэг татварын бус орлого	32640429.00	200251639.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	31824929.00	181154596.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	815500.00	19097043.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355441490.00	399550205.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320790800.00	351784600.00

Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320790800.00	351784600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1080000.00	20526785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1080000.00	20526785.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18965900.00	19601900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18965900.00	19601900.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14604790.00	7636920.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14604790.00	7636920.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	357733514.40	429834709.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357733514.40	429834709.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349527403.91	428017474.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209689672.00	254501733.00
210101	Үндсэн цалин	195996881.00	239028100.00
210104	Урамшуулал	13692791.00	15473633.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25872670.51	32418336.03
210201	Тэтгэврийн даатгал	18253432.54	30043924.03
210202	Тэтгэмжийн даатгал	368000.00	2374412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1840000.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1152680.92	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4258557.05	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18581212.00	20105900.80
210301	Гэрэл, цахилгаан	3058872.00	3141739.80
210302	Түлш, халаалт	15522340.00	16964161.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22348804.00	27991968.00
210401	Бичиг хэрэг	1388000.00	1770300.00
210402	Тээвэр, шатахуун	18879906.00	18666516.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720000.00	900000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	854898.00	899920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	506000.00	595400.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5159832.00
2105	Нормативт зардал	30499634.00	39638047.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26328155.00	34376466.84
210502	Хоол, хүнс	4171479.00	5261580.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2102500.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	258500.00	0.00
210604	Урсгал засвар	1844000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	1572000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	1572000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15988087.00	21532650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15539987.00	20613270.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	450000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80000.00	22750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33000.00	100000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49100.00	33000.00
210807	Газрын төлбөр	6000.00	16030.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100000.00	297600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24444824.40	30256839.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3810380.00	1269860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	20634444.40	28986979.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8206110.49	1817234.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8206110.49	1817234.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8206110.49	1817234.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	30348404.60	169967134.72
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	30348404.60	169967134.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	355441490.00	399550205.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355441490.00	399550205.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320790800.00	351784600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320790800.00	351784600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1080000.00	20526785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1080000.00	20526785.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18965900.00	19601900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18965900.00	19601900.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14604790.00	7636920.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14604790.00	7636920.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	355441490.00	399550205.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355441490.00	399550205.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347235379.51	397732970.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209689672.00	254501733.00
210101	Үндсэн цалин	195996881.00	171574800.00
210102	Нэмэгдэл	0.00	62833300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	4620000.00
210104	Урамшуулал	13692791.00	15473633.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25872670.51	32418336.03
210201	Тэтгэврийн даатгал	18253432.54	22379573.42
210202	Тэтгэмжийн даатгал	368000.00	2861000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1840000.00	1972916.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1152680.92	505646.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4258557.05	4699199.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18923312.00	19592750.80
210301	Гэрэл, цахилгаан	3058872.00	3141739.80
210302	Түлш, халаалт	15864440.00	16451011.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25707296.00	25636736.00
210401	Бичиг хэрэг	1408000.00	1770300.00
210402	Тээвэр, шатахуун	18879906.00	18666516.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720000.00	900000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	699990.00	899920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3999400.00	3400000.00
2105	Нормативт зардал	35479662.00	31522204.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25562655.00	25891785.00
210502	Хоол, хүнс	4742007.00	4458419.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5175000.00	1172000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11349300.00	8696700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5515400.00	8696700.00
210602	Тавилга	4149900.00	0.00
210604	Урсгал засвар	1684000.00	0.00
2107	Томиллолт, зочны зардал	0.00	1572000.00
210702	Дотоод албан томиллолт	0.00	1572000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15988087.00	21532650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15539987.00	20613270.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	450000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80000.00	22750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33000.00	100000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49100.00	33000.00
210807	Газрын төлбөр	6000.00	16030.00



Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100000.00	297600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4225380.00	2259860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4225380.00	2259860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8206110.49	1817234.57
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8206110.49	1817234.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8206110.49	1817234.57
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	0.00
14	Бусад эх үүсвэр	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	271,665,616.37	190,636,327.18	5,670,579.64	0.00	467,972,523.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,665,616.37	190,636,327.18	5,670,579.64	0.00	467,972,523.19
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,665,616.37	190,636,327.18	5,670,579.64	0.00	467,972,523.19
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	271,665,616.37	190,636,327.18	5,670,579.64	0.00	467,972,523.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,665,616.37	190,636,327.18	5,670,579.64	0.00	467,972,523.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	169,967,134.72	0.00	169,967,134.72
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,665,616.37	190,636,327.18	175,637,714.36	0.00	637,939,657.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
-----------------------	----------	-----------	-------------



		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357806200.00	346435379.51	389436000.00	377206185.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357806200.00	346435379.51	389436000.00	377206185.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357806200.00	346435379.51	389436000.00	377206185.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219200000.00	209689672.00	256535400.00	254501733.00
210101	Үндсэн цалин	203800000.00	195996881.00	171574800.00	171574800.00
210102	Нэмэгдэл	0.00		62833300.00	62833300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00		4620000.00	4620000.00
210104	Урамшуулал	15400000.00	13692791.00	17507300.00	15473633.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00		0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27600000.00	25872670.51	33162600.00	32418336.03
210201	Тэтгэврийн даатгал	18768000.00	17040670.51	22605500.00	22379573.42
210202	Тэтгэмжийн даатгал	441600.00	441600.00	2861000.00	2861000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2208000.00	2208000.00	2052300.00	1972916.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1766400.00	1766400.00	513100.00	505646.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4416000.00	4416000.00	5130700.00	4699199.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18965900.00	18923312.00	19601900.00	19592750.80
210301	Гэрэл, цахилгаан	3100000.00	3058872.00	3141900.00	3141739.80
210302	Түлш, халаалт	15865900.00	15864440.00	16460000.00	16451011.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	0.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25708300.00	25707296.00	26665400.00	25237036.00
210401	Бичиг хэрэг	1408300.00	1408000.00	1600000.00	1570300.00
210402	Тээвэр, шатахуун	18880000.00	18879906.00	19965400.00	18566816.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720000.00	720000.00	900000.00	900000.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700000.00	699990.00	800000.00	799920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4000000.00	3999400.00	3400000.00	3400000.00
2105	Нормативт зардал	34682000.00	34679662.00	19791700.00	13647119.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25507000.00	25506655.00	15366700.00	9916700.00
210502	Хоол, хүнс	4000000.00	3998007.00	3050000.00	2558419.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5175000.00	5175000.00	1375000.00	1172000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11350500.00	11349300.00	8522800.00	6696700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5516300.00	5515400.00	8522800.00	6696700.00
210602	Тавилга	4150000.00	4149900.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	1684200.00	1684000.00	0.00	0.00
2107	Томиллолт, зочны зардал	0.00	0.00	1350000.00	1320000.00
210701	Гадаад албан томиллолт	0.00	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томиллолт	0.00	0.00	1350000.00	1320000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16067000.00	15988087.00	21546100.00	21532650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15556000.00	15539987.00	20625100.00	20613270.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.00	180000.00	450000.00	450000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80000.00	80000.00	23000.00	22750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33000.00	33000.00	100000.00	100000.00



Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50000.00	49100.00	33000.00	33000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00	0.00	0.00
210807	Газрын төлбөр	8000.00	6000.00	17000.00	16030.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100000.00	100000.00	298000.00	297600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4232500.00	4225380.00	2260100.00	2259860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4232500.00	4225380.00	2260100.00	2259860.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357806200.00	357806200.00	389436000.00	379023420.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357806200.00	357806200.00	371386500.00	371386500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	357806200.0	357806200.0	351784600.00	351784600.00
131008	Орон нутгийн төсвөөс /Тогмол зардал/			19601900.00	19601900.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	0.00	18049500.00	7636920.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.0	0.0	18049500.00	7636920.00
122002	Хандив тусламж /гадаад/	0.0	0.0	0.00	0.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	0.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.0	0.0	0.0	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	20526785.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	20526785.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	20526785.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	399700.00
210401	Бичиг хэрэг	-	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	99,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
2105	Нормативт зардал	0.00	17875085.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	15,975,085.00
210502	Хоол, хүнс	-	1,900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	252000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	-	252,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Болортуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чулуунхороот сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чулуунхороот сумын ЭМТ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Чулуунхороот сумын ЭМТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 429,992.2 мянган төгрөгөөс тооцон 8,599.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,596.6 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 169,967.2 мянган төгрөгөөр буюу 36,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	26,803.7	35,861.5	9,057.8
Үндсэн хөрөнгө	502,112.8	692,009.2	189,896.4
Элэгдэл	-60,944.0	-89,931.0	-28,987.0
Нийт хөрөнгө	467,972.5	637,939.7	169,967.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	467,972.5	637,939.7	169,967.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	467,972.5	637,939.7	169,967.2

Авлага дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 35,861.5 мянган төгрөг болж 9,057.8 мянган төгрөгөөр өссөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 692,009.2 мянган төгрөг болж 189,896.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын их засвар хийж, дээд шатны байгууллагаас автомашин өгсөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 637,939.7 мянган төгрөг болж 169,967.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Чулуунхороот сумын ЭМТ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 211,719.9 мянган төгрөгөөр буюу 54,5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь хөрөнгө авсан, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нэмнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 72,101.1 мянган төгрөгөөр буюу 20,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт цалин хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь Засгийн газраас цалин хөлс нэмсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 389,436.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 389,436.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /код-71601/ хөтөлбөрийн 1 /код-80302/ арга хэмжээг санхүүжүүлэхээр 16,903.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, /71602/ хөтөлбөрийн 372,532.3 мянган төгрөгийг улсын төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 379,023.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 377,206.2 мянган төгрөгийг зарцуулж 1,817.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 377,206.2 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь нормативт зардал, хангамж бараа материалын зардал, гэрээт ажлын хөлсийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь цар тахалтай холбоотой зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны орлогыг дээд шатны төсвийн захирагчаас олгосон 20,526.8.0 мянган төгрөгийн орлогоор бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 20,526.8.0 мянган төгрөгийг 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл



стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 3 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,592.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,592.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал гараагүй тул залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 61,333.8 мянган төгрөгийн, худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй 2,050,7 мянган төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 749,5 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Чулуунхороот сумын ЭМТ нь 3 мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан нь Шилэн дансны 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4-д."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд хийсэн 2,592.6 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.5 дахь хэсэгт "... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5 дахь заалт Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Чулуунхороот сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/98/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Чулуунхороот сумын ЭМТ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд хийсэн 2,592.6 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй	2,592.6	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ц.Болортуяа Н.Оюунчимэг
2	Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг тулган шалгахад нийт 137 мэдээ байршуулах ёстойгоос тухайн жилийн төсөв, хөрөнгө оруулалт, орон тооны мэдээлэл зэрэг 3 мэдээллийг хоцроон мэдээлсэн байна		Албан шаардлага	Дарга	Ц.Болортуяа
ДҮН		2,592.6			